



ХАРИЛЦАА ХОЛБООНЫ  
ЗОХИЦУУЛАХ  
ХОРОО



ХҮҮХДИЙГ ЗОХИСГҮЙ  
АГУУЛГААС ХАМГААЛАХ  
ЗӨВЛӨЛ

## ХҮҮХДИЙГ ЗОХИСГҮЙ АГУУЛГААС ХАМГААЛАХ РАДИО, ТЕЛЕВИЗИЙН ХӨТӨЛБӨРИЙН ДҮРМИЙН ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ТАВИХ ОРОН ТООНЫ БУС ЗӨВЛӨЛИЙН 2026 ОНЫ 1-Р УЛИРЛЫН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТАЙЛАН

**Хэзээ:** 2026 оны 03-р сарын 17-ны Мягмар гарагийн 10:00 - 12:00 цаг

**Хаана:** Харилцаа холбооны зохицуулах хорооны 12 давхрын хурлын зааланд  
Метро бизнес төв . А блок, 12 давхарт

Харилцаа холбооны зохицуулах хорооны (ХХЗХ) дэргэдэх Хүүхдийг зохисгүй агуулгаас хамгаалах радио, телевизийн хөтөлбөрийн дүрмийн хэрэгжилтэд хяналт тавих Орон тооны бус зөвлөлийн 2026 оны нэгдүгээр улирлын ээлжит хурал 03 дугаар сарын 17-ны өдөр зохион байгуулагдлаа.

Тус зөвлөл нь Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.7 (а) дахь хэсэгт заасан Харилцаа холбооны зохицуулах хорооны чиг үүргийн хүрээнд улирал тутам хуралдаж, дүрмийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр ажиллаж байна. Тодруулбал:

- Радио, телевизээр зохисгүй агуулгатай контент, нэвтрүүлэг нэвтрүүлсэнтэй холбоотой иргэдийн өргөдөл, гомдлыг хүлээн авч хэлэлцэх;
- 18+ насны ангилалтай кино, бүтээлийг цагийн хязгаарлалт зөрчиж нэвтрүүлсэн эсэхэд хийсэн хяналт, мониторингийн дүн;
- Өдрийн цагаар Хөтөлбөрийн дүрэм зөрчсөн байж болзошгүй илт зохисгүй гэж үзэх агуулга нэвтрүүлсэн нь бүртгэгдсэн тайланг хэлэлцэх;
- Цаашид авах арга хэмжээний санал боловсруулж, хуралдаанаас гарсан санал дүгнэлтийн дагуу зөвлөмж, мэдэгдлийг холбогдох радио, телевизүүдэд хүргүүлж, зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч, үр дүнг олон нийтэд тогтмол мэдээлж байна.

### **2026 оны 1-р улиралд зохисгүй агуулгатай гомдол ирсэн эсэх**

Хүүхдийг зохисгүй агуулгаас хамгаалах Радио, телевизийн хөтөлбөрийн дүрэм зөрчсөн гэх кино, нэвтрүүлэг, эсхүл тухайн бүтээлийн зохисгүй агуулгатай хэсгийг тухайлан заасан гомдол тус хороонд ирээгүй.

Харин кино ерөнхий агуулгаараа зохисгүй шинжтэй болон үйлчилгээний орчин дахь хүүхэд хамгааллын асуудлаар ирүүлсэн гомдол, мэдээлэл бүртгэгдсэн байна. Тухайлбал:

ДДЭШ ТВ ХХК-ийн олон суваг дамжуулах үйлчилгээний “Кино сан” цэсийн “Бүх кино” хэсэгт байршуулсан насанд хүрэгчдийн киноны трейлер нь хүүхэд, залууст зохисгүй, илт садар самуун агуулгатай төдийгүй ямар нэг техникийн хязгаарлалтгүйгээр нээлттэй байгаа тухай гомдлыг тус хороонд ирүүлсэн.

Мөн телевизээр нэвтрүүлж байгаа зарим уран сайхны болон олон ангит кино нь хүүхэд залуусын сэтгэхүйд буруу үлгэр дуурайл болохуйц, сэдэл төрүүлэх агуулгатай байна гэсэн ерөнхий агуулгатай, тодорхой киноны нэр дурдаагүй 3 гомдол тус хороонд болон иргэд олон нийттэй харилцах 11-11 төвд ирүүлсэн байна.

### **Энэ удаагийн зөвлөлийн хуралдаанаар радио, телевизийн хөтөлбөрт хүүхдийг зохисгүй агуулгаас хамгаалах чиг үүргийнхээ хүрээнд дараах асуудлыг хэлэлцлээ.**

1. Телевизүүдийн хөтөлбөрийн хяналт, мониторингийн 2025 оны 11,12 дугаар сар, 2026 оны 1, 2 дугаар сарын дүнгээс 18+ тэмдэглэгээтэй кино, нэвтрүүлгийг цагийн хязгаарлалт зөрчиж өдрийн цагаар болон 22:00 цагаас өмнө нэвтрүүлсэн болон Радио, телевизийн хөтөлбөрийн дүрмээр хязгаарласан, илт зохисгүй гэж үзэж болох агуулга нэвтрүүлсэн нь бүртгэгдсэн тайлан, танилцуулга;
2. Орон тооны бус зөвлөлийн 2025 оны 4-р улирлын хурлаас гарсан дүгнэлтийн дагуу телевизүүдэд хүргүүлсэн зөвлөмж, мэдэгдлийн хэрэгжилт, зөрчлөө давтсан эсэх;
3. Харилцаа холбооны зохицуулах хороонд ирүүлсэн дээрх гомдлуудыг хэрхэн шийдвэрлэж байгаа тухай мэдээлэл;
4. Өргөн нэвтрүүлгийн орчинд хүүхдийг зохисгүй агуулгаас хамгаалах чиглэлээр хууль эрх зүйн орчинд тулгарч буй асуудал, холбогдох хууль, нөхцөл шаардлагад нэмэлт өөрчлөлт оруулах дараах нийтлэг зөрчилтэй холбоотой асуудлаар хэлэлцэж, санал бодлоо солилцлоо.

Өргөн нэвтрүүлгийн үйлчилгээ эрхлэгч нь кино, нэвтрүүлэг гаргахдаа:

- Цагийн хязгаарлалт зөрчих
- Насны ангиллын тэмдэг тэмдэглэгээг байршуулаагүй-Зохисгүй агуулгатай
- Насны ангиллын тэмдэглэгээг Монгол Улсад мөрдөгдөж буй хууль тогтоомж, стандартын дагуу байршуулаагүй, буруу тавьсан
- Хуульд заасан хортой, хориотой, зохисгүй агуулгыг хаах, хязгаарлах үүргээ биелүүлээгүй зэрэг зөрчлүүдийг хууль, дүрэм, журмаар хэрхэн зохицуулж хяналт хийдэг, зөрчлийн хариуцлагыг Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд хэрхэн тусгасан, харьяалал нь хэнд хамаардаг талаар танилцуулж, хуулийн хэрэгжилтийг сайжруулах чиглэлээр хариуцлага, харьяаллыг тодорхой болгох, холбогдох хуульд нэмэлт өөрчлөлт оруулахаар санал өгөх талаар хэлэлцэж, санал нэгдэв.

- Түүнчлэн Хүүхэд хамгааллын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.12-т заасан, хэвлэл мэдээлэл, олон суваг дамжуулах болон цахим орчны үйлчилгээ эрхлэгчийн цахим орчин, өргөн нэвтрүүлгээр түгээсэн контент, мэдээ, мэдээлэл, бүтээл нь хүүхдэд хортой агуулгатай эсэхэд дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлөөс батлан гаргах **хортой агуулгыг тогтоох шалгуур** боловсруулах ажилд холбогдох санал хүргүүлж ажиллах нь зүйтэй гэж зөвлөлийн зарим гишүүд үзэв.
- Энэ хүрээнд өргөн нэвтрүүлгийн орчинд хүүхдийг зохисгүй агуулгаас хамгаалахтай холбоотой ирүүлдэг гомдлыг шийдвэрлэхэд тулгарч буй бэрхшээл, тухайлбал кино, бүтээлийг бүхэлд нь зохисгүй агуулгатай гэж ерөнхийлөн илэрхийлсэн гомдлыг шийдвэрлэхэд хүндрэл үүсэж буй асуудлыг танилцуулж, санал хүргүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

## Мониторингийн үр дүнд илэрсэн нийтлэг зөрчлүүд - 2025 оны 11-12 сар, 2026 оны 1-2 саруудад

### Өдрийн болон оройн цагт 18+ ангилалтай контент нэвтрүүлэх

- 06:00–22:00 цагийн хооронд 18+ тэмдэглэгээтэй, зохисгүй агуулгагүй кино, нэвтрүүлэг нэвтрүүлсэн таван телевиз (**Стар, ТВ8, Channel 11, Хөгжил ТВ, Баянхонгор телевиз**) бүртгэгдэв.

### 18+ насны ангилалтай киног өдрийн цагаар гаргасан зөрчил

- Кино нэвтрүүлэхдээ насны ангиллын тэмдэглэгээг MNS 6587:2020 стандартын дагуу зөв тогтоож байршуулаагүй - 1 телевиз бүртгэгдсэнээс Дербес телевиз нь 22:00 цагаас өмнө буюу өдрийн цагаар Радио, телевизийн хөтөлбөрийн дүрмээр хязгаарласан, илт зохисгүй гэж үзэж болох агуулгатай контент нэвтрүүлсэн нь бүртгэгдсэн.

1. Зөрчлийг хянан үзээд Дербес телевиз нь насны ангиллын тэмдэглэгээг буруу байршуулж, Хүүхдийг зохисгүй агуулгаас хамгаалах, Радио, телевизийн хөтөлбөрийн дүрмийн 2.5.4-д хязгаарласан зохисгүй агуулгатай киног нэвтрүүлсэн гэж дүгнэлээ. Иймд тус телевизэд кино нэвтрүүлэхээс өмнө Өргөн нэвтрүүлгийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хууль, Хүүхдийн дүрэмд заасан, холбогдох хуулиар хязгаарласан хориотой, хортой, зохисгүй агуулга байгаа эсэхийг редакцадаа хянаж байх, насны ангиллын тэмдэг тэмдэглэгээг байршуулж, цагийн хязгаарлалтыг мөрдөх, 18+ ангилалтай кинонд зохисгүй агуулгатай хэсгийн дууг хаах, дүрсийг бүдгэрүүлэх зэрэг техникийн арга хэмжээ авч ажиллах, зөрчлийг давтахгүй байхыг анхааруулах нь зүйтэй гэж дүгнэв.
2. Өдрийн болон оройн цагт буюу 06:00-22:00 цагийн хооронд 18+ насны ангилалтай кино нэвтрүүлж, цагийн хязгаарлалтыг зөрчсөн хэдий ч зохисгүй агуулга нэвтрүүлээгүй **Стар, ТВ8, Channel 11, Хөгжил ТВ, Баянхонгор** телевизүүдэд Харилцаа холбооны зохицуулах хорооны Өргөн нэвтрүүлгийн зохицуулалтын газраас хөтөлбөрийн хяналт, мониторингийн хүрээнд анхааруулга, мэдэгдэл хүргүүлэхээр болов.
3. ДДЭШ ХХК-ийн кино санд байршуулсан киноны трейлертэй холбоотой гаргасан гомдлын дагуу уг киног хянаж үзэхэд **насанд хүрэгчдэд зориулсан киноны**

**трейлерийг ямар нэгэн техникийн хязгаарлалтгүйгээр** нээлтэй байршуулсан нь тогтоогдсон.

Уг үйлдэл нь Хүүхэд хамгааллын тухай хуулийн 25.7, 25.8, 25.9, Өргөн нэвтрүүлгийн тухай хуулийн 27.1.1, Олон суваг дамжуулах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийн нөхцөл шаардлага"-ын 6.2.8, 6.11-д заасныг тус тус зөрчсөн гэж үзэж, зөрчлийг **нэн даруй таслан зогсоох**, хүүхдийг зохисгүй агуулгаас хамгаалах зорилгоор хаах, түгжих, эцэг эхийн хяналтын тохиргоог хэрэгжүүлэх, цаашид холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг мөрдөж ажиллах талаар арга хэмжээ авах тухай албан тоот хүргүүлэв.